

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2010-ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

ХӨВСГӨЛ АЙМАГ

□	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1	2	3	4
<p>ЗОРИЛТ 2. ТӨСВИЙН ОРЛОГЫН СУУРИЙГ ӨРГӨТГӨХ, БҮРТГЭЛ ТООЦОО, МЭДЭЭЛЭЛИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАН ТӨСӨВТ ТӨВЛӨРӨХ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.</p>			
1	<p>Төсвийн орлогын боломжтой бүх эх үүсвэрийг бүрэн дайчилж, оновчтой хуваарилан, үр өгөөжтэй ашиглаж, төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангана.</p>	<p>Төсвийн тухай хуулийн хэрэгжилтээр</p>	<p>Анхан шатны нэгж байгууллагууд болон Цагдаагийн газар, ГХБХБГ, Улсын бүртгэлийн газар, Тээвэр авто замын газар зэрэг байгууллагуудаас орлого тооцох суурь үзүүлэлтийн судалгааг шинэчлэн гаргуулан авч судалгаа хийсний үр дүнд орлогыг бүрэн дайчилж, орон нутгийн төсвийн нийт орлого -2570,9 сая төгрөг буюу өмнөх оныхоос 527,7 сая төгрөгөөр нэмж төлөвлөн эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 106,0 сая төгрөгөөр давуулав. Орон нутгийн төсвийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн төсвийн мэдээллийн төлөөлөгчид болон урилгаар оролцож байгаа хүмүүсийг нээлттэй хангаж, Төрийн сангийн Spark [сүлжээг ашиглан бүх сумдын төсвийн хуваарийг сумдад хүргүүлж байна. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг ханган ажиллах тухай Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж huvsgul.mn сайтад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбогдолтой аймгийн 2010 оны орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөг байгууллагаар, зардлын зүйлээр, 2009 оны аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгдсэн тайлан, 2009 оны аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайлбар, 2009 оны давсан орлогод тодотгол хийсэн аймгийн ИТХ-ын 2010 оны 36 дугаар тогтоолыг тавьж мэдээлэв. Мөн төсөв, санхүүгийн талаар улиралд 1-ээс доошгүй удаа</p>

			хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын дарга, эрхлэгч нарт мэдээлэл хийж байна. /Б-100%/
2	Төсвийн зарлагын хэмжээг орлогын эх үүсвэр болон эдийн засгийн өсөлттэй уялдуулж, үргүй зардлыг хязгаарлаж, өр, авлагыг багасган төсвийн зарлагыг суурь хэмжээнд хүртэл бууруулна.	Хөтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн хэрэгжилтээр	Сумдын төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагын нягтлан бодогч нарын сургалт, НББ-ийн Acolous 3.0 программын сургалтыг зохион байгуулж, 22-24 сумын төрийн сангийн төлөөлөгч, төсөвт байгууллагын нийт 120-150 няглан бодогчийг хамруулж, төрийн сангийн дотоод хяналт хийх хуваарь гарган санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар төрийн сангийн төлөөлөгч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргатай сумдын засаг дарга болон хэлтэс, агентлагийн дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд Монгол улсын Төсвийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах гэрээний биелэлтийг тооцон ажиллаж байна. Нийт сумд төрийн сангийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор Засгийн газрын бүртгэл мэдээллийн систем орон нутагт бүрэн хэрэгжиж гүйлгээ бүрт онлайнаар хяналт тавих боломж бүрдсэн. Аймгийн Засаг даргын 2010 оны 116 дугаар захирамжаар Аймгийн төрийн сангаас хийгдэж буй гүйдгээнд 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтанг шинэчлэн баталж мөрдөж байна. Засгийн газрын 2008 оны 256 дугаар тогтоолыг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчийн дунд хугацааны хөтөлбөрт суурилсан төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн дагуу 2011-2013 оны хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг ТЕЗ-ийн төсвийн саналын товчоо, ТЕЗ-ийн хөтөлбөрийн мэдэгдэл, ТЕЗ-ийн зарлагын төлөвлөлтийн мэдэгдэл, ТЕЗ-ийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, ТЕЗ-ийн хөтөлбөрийн өөрчлөлтийн мэдэгдэл гэсэн 5 үзүүлэлтээр боловсруулан аймгийн ИТХТХ-аар хэлэлцүүлж сангийн яаманд хянуулаад байна. /Б-90%/
3	Татвар хураалтын үйл ажиллагааг боловсронгуй болгож, татвар төлөгчдийг татварт хамруулах түвшинг дээшлүүлж, бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог бүртгэлжүүлэн далд эдийн засгийн нөлөөлөлийг багасгаж, түүнийг илрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Татвар төлөгчдийн хамралтын өсөлтийн хувь, татварын орлогын хэмжээ /мян.төг/	Татвар хураалтын ажлыг эрчимжүүлж, иргэдтэй ажиллах ажиллагааг сайжруулах, ялангуяа худалдаа, үйлчилгээний төв, барилгын материалын цэгүүдийн үйл ажиллагааг хяналтандаа авч ажиллан НӨАТ нэгдсэн арга хэмжээн зохион байгуулсан. Татвар төлөгчтэй жигд ажиллах үүднээс аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 65 ижил төстэй супермаркет, үйлчилгээний төвүүдийн татварын тайлан ногдуулалтыг 4 ажлын групп болон шалгаж НӨАТ төлөгчийг шинээр 18-аар нэмэгдүүлэх боллоо

			<p>Татвар ноогдуулалт төлөлтөнд судалгаа шинэжилгээ хийн 420 гаруй хуулийн этгээдэд татварын өр барагдүүлэх график гаргаж татвар нэн даруй төлөх тухай болон төлөөгүйгээс үүдэх хариуцлага, татварын бусад мэдээллийн талаар албан тоотыг хариуцсан ТУБ бүрээр хүргүүлж татвар төлөгчөөр татварын хуулийн хариуцлагын талаар танилцсан тухай баталгаажуулалт хийлгэж мөн тайлант өр болон урьд оны өрийг төлөх албан ёсны баталгаа гаргуулж ажиллаж байна.</p> <p>/Б-90%/</p>
4	<p>Татвар төлөх нийгмийн сэтгэлгээг хөгжүүлэн татварын тэгш шударга байх зарчмыг баримтлан, мэдээллийн тогтолцоог сайжруулж, татварын цахим тайлан хүлээн авах бэлтгэл хангаж, сумдын татварын байцаагч нарыг компьютер, техник хэрэгслэлээр хангана.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>5-р сард нээлттэй өдөрлөг зохион байгуулж бүх сум болон аймгийн төвийн иргэд, төсвийн байгууллагын нягтлан бодогч, төрийн сангийн төлөөлөгч нарт татварын шинэ хууль, хөнгөлөлт чөлөөлтийг хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт чөлөөлөлтийг хэрхэн эдлэх, татварын бүртгэл, төрийн татварын үйлчилгээ, татвар ноогдуулалт, өр барагдүүлэх талаар сургалт, танилцуулга хийсэн нь татвар төлөгчдийн зүгээс ихээхэн талархал хүлээсэн ажил боллоо.</p> <p>Ихээхэн өртэй татвар төлөгчдөд мэдэгдэх, хуудас, мэдэгдэл, албан шаардлага өгч, банкин дахь данс хаах зэрэг үйл ажиллагаа явуулж ажилласнаар татварын нийт өрийн 87.1 хувийг барагдуулсан. Нэг цэгийн үйлчилгээний тусгай өрөөг тохижуулан татварын хууль тогтоомж, заавар аргачлалыг татвар төлөгчдөд танилцуулах, татварын тайлан хүлээн авах, тодорхойлолт өгөх зэрэг үйлчилгээг хүргэж байгаа бөгөөд стандарт үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Аймгийн татварын хэлтэс Онлайнд холбогдож хөндлөнгийн мэдээллийн санг өргөжүүлэх ажлын хүрээнд холбогдох газраас ирүүлсэн татвар төлөгчдийн мэдээллийг мэдээллийн баазад бүртгэх, НӨАТ - н падааныг баазад оруулах гэх мэт ажлуудыг хийж Татварын хяналт шалгалтандаа ашиглаж байна. Одоогоор сумдын татварын байцаагч нарыг компьютер техник хэрэгслээр хангах ажил хийгдээгүй байна.</p> <p>/Б-50%/</p>
<p>ЗОРИЛТ 3. БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ, ТӨРИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЭЛ, ДОТООД АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТЛОЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО:</p>			

5	<p>Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгох хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах арга хэмжээ авна.</p>	<p>Зээлийн хүүгийн бууралт</p>	<p>Аймаг сумын банк бүгд online-аар холбогдон ирээдэд банкны үйлчилгээ үзүүлж, аймгийн төвийн 6 банк орчин үеийн технологид суурилсан АТМ, ПОС, internet banking, SMS banking, mobile banking болон бусад үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Манай аймагт нийт 4 АТМ, 25 ПОС терминал машин томоохон худалдаа үйлчилгээний төв, дэлгүүрүүд дээр ажиллаж байгаа бөгөөд банкууд өөрсдийн онцлог нөхцөлд тохирсон бусад үйлчилгээнүүдийг зах зээлд нэвтрүүлж байна.</p> <p>Цахим банкаар үйлчлүүлэгчдийн тоо 12,0 мянгад хүрсэн байна.Арилжааны 6 банкаар зээлийн 6 бүтээгдэхүүнээр 2010 оны эхний хагас жилийн байдлаар 35.0 мянган иргэн аж ахуйн нэгжид 16.3тэрбум төгрөгийн зээлийг олгосноос Зээлийн хүү дунджаар 2008 оноос 3.4 %-иар буурсан байна</p> <p>/Б-100%/</p>
6	<p>Төрийн байгууллагын үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн бүртгэл, тайлагнал, дотоод аудит, хяналт-шинжилгээний тогтолцоог оновчтой бүрдүүлж, үр нөлөөг дээшлүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланг УСНББОУСтандартад нийцүүлэх, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд оршиж буй зөрчил дутагдлыг арилгаж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл, тайлангийн стандарт горим, төлөвлөлтийн арга зүйг мөрдөх талаар хүлээх хариуцлагыг дээшлүүлж, удирдлагын шийдвэр гаргахад санхүүгийн болон дотоод мэдээ, тайлангийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, аудитын хараат бус байдлыг хангах, аудитын компаниудын чадавхийг нэмэгдүүлж, хариуцлагыг сайжруулах, бүртгэлийн ажилтны мэдлэг чадварыг үе шаттай дээшлүүлэх зорилгоор “Нягтлан бодох бүртгэлийг сайжруулах” аймгийн хөтөлбөр батлуулан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний дагуу Мөрөн сумын 300-аад аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтөлөлт, санхүү, татварын тайланг үнэн зөв гаргах талаар аймгийн Татварын хэлтэс, хараат бус аудитын компаниуд, ММНБИ-ийн Хөвсгөл салбарын гишүүдийн бүрэлдэхүүнтэй шалган зөвлөх үйлчилгээг эхлээд байна.</p> <p>Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор Сангийн яам,МНБИ-тай хамтран дотоод аудитын сургалтыг 2010 онд зохион байгуулж 120 хүнийг</p>

			хамрууллаа. /Б-90%/
7	Хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлж, ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд чухал ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлнэ.	Шинээр бий болсон ажлын байрны тоогоор	2010 оныг "Бизнесийн орчны шинэтгэлийн жил болгон зарлаж, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж, орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний 5 зорилт, 36 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан биелэлтийг тооцон холбогдох дээд байгууллагуудад улирал тутам тайланг хүргүүлэн ажиллав. 2010 оны эхний 11 сарын байдлаар 2,1 тэрбум төгрөгийн ЖДҮ-ийн сан бүрдүүлсэн ба ЖДҮ-ийг дэмжих хөнгөлттэй зээлийн 3 төрлийн эх үүсвэрийг ХААН, Хадгаламж, Төрийн банкуудаар дамжуулан олгож байна. Оны эхнээс 376 аж ахуйн нэгж 900 гаруй ажлын байр шинээр бий болгоод байна. /Б-100%/
Хоёр. Бодит салбарын бодлогын хөгжлийн хүрээнд:			
ЗОРИЛТ 6. ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЖ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГЫГ ӨНДӨРЖҮҮЛЖ, ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ.			
1	Нутгийн шилмэл омог, ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах замаар цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх, эрчимжсэн аж ахуйг дэмжинэ.	Цөм сүргийн тоо /мянган толгойгоор/	2010 онд Дархад омгийн хонь, эрчим омгийн ямаа болон бусад нутгийн хэвшлийн малаас Хөвсгөл цөм сүргийн үржлийн нэгжтэй хамтран эх малаас цөм сүрэг бүрдүүллээ. Цагаан-Уул суманд 3000 эм хонь, Төмөрбулаг суманд 302 эм ямаа, Ренчинлхүмбэ суманд дархад омгийн 400 гаруй эм хониор цөм сүрэг бүрдүүлээд байна. ЖДҮ-г дэмжих төслийн хүрээнд сүүний үхрийн аж ахуй эрхлэх 5 иргэнд аж ахуйн нэгжийн төсөл шалгаран 118,0 сая төг-ний зээл олгосон. /Б-100%/
2	Гойд ашиг шимт мал болон цөм сүргийн малыг бүртгэлжүүлж, малын гарваль, ашиг шим, эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болгох, орон нутгийн мал эмнэлэгийн үржлийн ажил, үйлчилгээг дэмжиж, 500,0 мянган толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийж чанарын шаардлага хангасан хээлтүүлэгч малыг үржилд ашиглана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2010 онд аймгийн хэмжээгээр нутгийн омог, хэвшлийн малыг өсгөн үржүүлдэг Ренчинлхүмбэ, Төмөрбулаг, Цагаан-уул, Цэцэрлэг, Улаан-уул, Арбулаг, Мөрөн, Тариалан, Их-уул, Эрдэнэбулган сумдын 40876 толгой малд үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн. Мөн Ренчинлхүмбэ, Тариалан, Их-уул, Эрдэнэбулган, Мөрөн сумдад нутгийн болон сүү, махны хэвшлийн 1687 үхэрт үзлэг ангилалт, хянан баталгаажуулалт хийсэн байна. /Б-100%/
3	Мал, амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах замаар мал аж	Бэлтгэх байгалийн хадлангийн	2010 онд аймгийн хэмжээгээр сумдад 130.0 мян.тн байгалийн хадлан, 366 тн гар тэжээл бэлтгэх өвс, тэжээлийн даалгавар өгсөнөөс оны эхний 11 сарын

	ахуйг аливаа эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлж, отрын бүс нутгийг хамгаална.	хэмжээ	байдлаар 147052.2 тонн байгалийн хадлан, 272 тн сүрэл, 325 тонн гар тэжээл бэлтгэн нөөцлөөд байгаа нь хадлангийн төлөвлөгөөг 113,0, гар тэжээлийн төлөвлөгөөг 88,8 хувиар биелүүлэв. Аймгийн Засаг даргын захирамжаар отрын бүс нутгийг шинэчлэн тогтоох ажлын хэсгийг томилон 2001 оны аймги йн ИТХ-ын хурлын 03 т дугаар тогтоолоор отроор өвөлжих бүс нутгаар тогтоогдсон 11 сумын 245585 га бэлчээрийн талбайн ашиглалтын байдалд үнэлгээ хийж өмнө тогтоосон шийдвэрийг хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн. Мөн өвөлжөө хаваржааны нутгийг зун, намрын цагт сэлгэх отор нүүдлийг тодорхой хугацаанд зохион байгуулах шийдвэр гаргаж хэрэгжүүлэв. /Б-100%/
4	Бэлчээр, тариалангийн талбайн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулна.	Үлийн цагаан оготной тэмцэх талбайн хэмжээ /мянган га/	2010 онд Цэцэрлэг-10, Цагаан-Уул-9, Шинэ-Идэр-5, Бүрэн тогтох-6.0 га нийт 30 мянган га талбайд хийхээр сумдын Засаг дарга нартай нь ажлын гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажиллаж, уг ажлыг гэрээний дагуу хийж дуусгав. Устгалын зардал болох 44,3 сая төгрөг зарцуулахаас 39,0 сая төгрөгийн санхүүжилт олгож, үлдэгдлийг тайлан тушаасны дагуу холбогдох сумдах сумдад олгохоор гэрээ хийгдсэн. /Б-100%/
5	Хүн амын усан хангамжийг сайжруулах зорилгоор сум бүрт худаг гаргаж хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах, бэлчээрийг усжуулах, иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжинэ.	Шинээр гаргах хүдгийн тоо	Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд суманд 9гар худаг, ХЯБХН-ийн хөрөнгөөр 7 суманд 7 нийт 16 худаг шинээр, 10 сумын 10 хүдгийг засварлаж, Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд засварын 3, УИХ гишүүн Сэвдэнчиг гишүүний багцаас 3 худаг шинээр, Энхтүвшин гишүүний багцаас шинээр 1 худаг. Аймгийн дүнгээр нийт 33 худаг шинэчилэн засварлав. Эдгээр ажлыг гүйцэтгэхэд Хөвсгөл Ундрага ХХК, Хөвсгөл Геологи ХХК, Идэрчандмань ХХК, Булган ундрага ХХК-ууд шалгарч, 28 худаг хүлээн авч, 5 худаг тодорхой шалтгааны улмаас гараагүй байна. /Б-70%/
6	Малын гоц халдварт болон паразиттах өвчний гаралтыг бууруулах, зарим халдварт өвчнөөс эрүүлжүүлж, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Малын халдварт ба паразиттах өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 63,3 хувиар буурч, ариутгал халдваргүйтгэлд 676,3 мян м кв талбай, 476536 хашаа байр, 296 тн өтөг бууц, 14105 худаг уст цэг, 4813 булаг шанд, 2954 ш тоног хэрэгсэл хамруулсан байна. /Б-100%/
7	Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжих,	Шаардлага хангасан мал	Хөвсгөл аймагт мал эмнэлэг үржлийн 57 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд мал эмнэлгийн, мал

	эмчилгээ, үржлийн ажил, үйлчилгээний чанарыг сайжруулах, оношлогооны чадавхийг дээшлүүлнэ.	эмнэлэг, нэгжийн тоо	эмнэлэг үржлийн, үржлийн гэсэн чиглэлээр тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. МӨН мал эмнэлэг, үржлийн аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор тэдний үйл ажиллагаагаа өргөтгөхөд нь зориулж, 3 аж ахуйн нэгжид 31.0 сая төгрөгийн зээл олгосон. /Б-90%/
8	"Атрын III аян"-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд гол мөрөн бусад эх үүсвэрээр усан сан байгуулж, усалгаатай газар тариалан хөгжүүлэх санаачилгыг дэмжиж, газар ашиглалтыг сайжруулж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, усны хэмнэлттэй технологи нэвтрүүлнэ.	Усалгаатай газар тариалангийн талбайн өсөлтөөр	2010 онд 552 га талбайд усалгаатай үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж, Рашаант сумын Улаан-Од ХХК 374.1 сая төгрөгний төсөвт өртөг бүхий 64 га талбайн услах услалтын систем, Мөрөн сумын иргэн Л Дүүрэнжаргал Түнэл сумын Олны өтөгт 55.9 сая төгрөгний төсөвт өртөг бүхий 10 га талбайг услах услалтын систем барьж улсын комисст хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд 2010 онд усалгаатай талбай 74 га-гаар нэмэгдсэн. /Б-100%/
9	Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, гурил, төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл, хангамжийг сайжруулна.	Дотоодын ургацын хэрэгцээт улаан буудай, төмс, хүнсний ногооны хэрэгцээ хангалтын хувиар	2010 онд 14038 га талбайд үр тариа тариалсанаас улаанбуудай 13970 -д, арвай 48, овъёос 20, тосны ургамал 100 га-д тус тус тариалж, 13228 га талбайд уриншын боловсруулалт хийсэн. 2010 оны эцсийн байдлаар 17819.4 тн улаан буудай, 2762.9 тн төмс, 1357.8 тн хүнсний ногоо хураан авч гурилын хэрэгцээг 100, төмсний хэрэгцээг 40,4, хүнсний ногооны хэрэгцээг 14,5 хувиар хангасан байна. /Б-100%/
10	Хөрсний үржил, шимийг дээшлүүлэх, нэгжээс хураан авах ургацыг нэмэгдүүлэх бордооны үйлдвэрлэлийг дэмжинэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөрсний үржил шимийг дээшлүүлэх нэгжээс авах ургацыг нэмэгдүүлэх зорилгоор сэлгээг зөв зохистой ашиглах тэг элдэншүүлэх технологиор 2000 гаруй га талбайд уриншийн боловсруулалт хийж, төмс, хүнсний ногооны талбайг жил бүр бууцаар бордож хэвшээд байна. /Б-100%/
11	Сүү бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрийн аргаар боловсруулах сүүний хэмжээг нэмэгдүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ/мян.л/	2010 онд Титаник ХХК, Цагаан-Үүр сумын цехүүд иргэд малчдаас 119,7 мянган л сүү, Октаэдр ХХК нь малчдаас 47,6 тн сүү тус тус хүлээн авч 49,7 мянган л тарга, 14,4 тн ааруул, 2,3 тн цөцгий, 7,2 мян л ариутгасан сүү үйлдвэрлэв. Сүү хөтөлбөрийн хүрээнд Окта-Эдр ХХК, Галт сумын иргэн Нэргүй нарт сүүний цех байгуулах эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэхэд нь зориулж, 35,0 сая

			төгрөгийн зээл олгосон. /Б-100%/
12	Европын стандартын шаардлага хангасан мах боловсруулах үйлдвэр байгуулж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлнэ.	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээ	Мөрөн суманд байгуулагдсан "Мах маркет" үйлдвэр нь мал авах бэлтгэлээ хангаад, одоогоор нядалгаа хийгдэж эхлээд байна. Аймгийн Засаг дарга 2009 онд ОХУ-ын Тува улстай хамтран ажиллах санамж бичгт гарын үсэг зурсны дагуу ХХААХҮЯ-наас тусгай зөвшөөрөлтэй аймгийн Идэр чандмань, Бат чандмань ХХК-үүд ОХУ-ын Тува улсын Уургай ХХК-тай үржлийн хонь, хонины мах нийлүүлэх гэрээ байгуулсан. 2010 онд Жаст Агро ХХК 3728 үхэр, 572 адууг үйлдвэрийн аргаар нядалж, 637,6 мянган тонн мах бэлтгэсэн байна. /Б-100%/
13	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжсэн хөрөнгө оруулалт, хөнгөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, үүний зарим хэсгийг зээлийн баталгааны сан, тоног төхөөрөмжийн лизинг, хүүгийн хөнгөлөлт бий болгоход зарцуулна.	Олгосон зээл, хүүгийн хөнгөлөлтийн хэмжээ /сая төгрөгөөр/	ЖДҮ хөгжүүлэх сангаас 2010 онд Хадгаламж банкинд 650.0 сая, Төрийн банкинд 2009 оны зээлийн эргэн төлөлт, нэмэлт санхүүжилтын 70.0 сая, УИХ-ын гишүүн Ц. Сэдванчиг гишүүний багцаас 155.0 сая 2009 оноос Ц.Даваасүрэн гишүүний багцаас 400.0 сая төгрөг тус тус төвлөрсөн. Лизингийн зээлээр олгох Сүү боловсруулах, Эсгий хийх, Арьс элдэх машины тоног төхөөрөмжийн төслийн материал ирснийг радио телевизээр зарлан сурталчилж байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас санхүүгийн түрээсийн үйлчилгээ, ХАС лизингийн үйлчилгээ үзүүлэн иргэдэд таниулах сурталчилгаа хийж байна. /Б-90%/
14	Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг шинжлэх шинэ арга аргачлалыг нэвтрүүлж, согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн Засаг даргын 2010 оны А/190 дүгээр захирамжийн дагуу ажлын 5 хэсэг байгуулж, нийт 13 суманд архи дан согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, сурталчлах, түүгээр үйлчлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлагын биелэлтийг тусгай үзүүлэлтээр үнэлсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор 19 албан шаардлага, 13 акт, 5 дүгнэлт гарган холбогдох хүмүүст хүргүүлэв. Зохих зөвшөөрөлгүй, шинжилгээ дүгнэлтгүй 18 нэрийн нийт 1972.2 мянган төгрөгийн согтууруулах ундааг хурааж, улсын орлого болгон шийдвэрлэж, зөрчил гаргасан 19 албан тушаалтан, иргэнд 1130.0 мянган төгрөгийн торгууль оногдуулав. /Б-100%/
15	Байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалд зохицсон мал аж ахуй, газар	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ЖДҮ-ийг дэмжих сангаас Мөрөн сумын ойролцоо сүүний

	тариалангийн эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, малчин, тариаланчдын бүлэг, хоршоо байгуулах ажлыг дэмжинэ.		үхрийн аж ахуй эрхэлж буй 6 иргэн, аж ахуйн нэгжийн эргэлтийн хөрөнгө, мал худалдан авч үйл ажиллагаагаа өргөтгөхөд нь зориулж, аймгийн салбар дэд комиссын шийдвэрээр 156,0 сая төгрөгийн зээл олгох шийдвэр гаргаж, санхүүжилтийг олгосноор мөрөн сумын хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгцээг хангаж байна. /Б-100%/
16	Гар урлал, бэлэг дурсгалын зүйл, хөнгөн блок, асфальт бетон зэрэг барилгын материалын импортыг орлох жижиг дунд үйлдвэр байгуулахыг дэмжинэ.	Объектын тоогоор	2010 онд ЖДҮ-ийг дэмжих сангаас гар урлал бэлэг дурсгал, хөнгөн битон үйлдэрлэхчиглэлд ирсэн төслүүдийг бодлогоор дэмжлээ Үүнд гар урлал Урлахуй төсөлд 8,0 сая Хөнгөн битон үйлдвэрлэх Хүслэнт бүтээмж компанийн төслийг 20,0 сая төгрөгөөр дэмжсэний гадна жуулчдын үйлчилгээнд зориулж, гар урлал, бэлэг дурсгалын тасгийг "Дөл" зочид буудалд нээн ажиллуулж эхлэв. /Б-70%/
17	Жижиг дунд үйлдвэрийн зээлийн даатгалын хуулийг батлах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор зээлийн баталгаа, зээлийн даатгал тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөвсгөл аймгийн "Үйлдвэржилтийн хөтөлбөр" боловсруулж, аймгийн ИТХ-ын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2010-2016 онд аймгийн Үйлдвэржүүлэлтийг дэмжих дэд хөтөлбөр болон Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлан мөрдөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан батлуулж мөрдөж ажиллахаар шийдвэрлэв. 2010 оны эхний 11 сарын байдлаар нийт 250 иргэн, аж ахуйн нэгжийг хөнгөлттэй зээлд хамруулаад байна. 2010 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээгээр өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дэмжих сан 2,1 тэрбум төгрөгт хүрээд байна. /Б-100%/
Зорилт 8. Хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ:			
18	Аймгийн Нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборыг өргөтгөж, багтаамжийг нэмэгдүүлж, хатуу хучилттай зурваст хүчитгэл хийн өргөтгөнө.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборын өргөтгөлийн зураг төсвийг Өрх ХХК гүйцэтгэж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, Гүйцэтгэгчээр Урагшлах ХХК Ажлыг гүйцэтгэж байна. /Б-70%/
19	Могойн гол-Мөрөнгийн 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж байгуулах ажлыг эхлүүлж, Ханх сумын цахилгаан эрчим хүчний найдвартай хангах асуудлыг судалж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын төсвийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Могойн гол-Мөрөнгийн 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барьж байгуулах ажлын зураг төсөв бэлэн болж, гүйцэтгэгчийг сонгох тендер зарласан. Ханх суманд улсын төсвийн хөрөнгөөр 2,5 км 0.4 кВ ЦДАШ шугам шинээр тавьж, 3 км хуучиншугамыг

	хэмжээ авна.		засварлаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 95 дугаар тогтоолоор 89,0 сая төгрөгийн эд хөрөнгийг Ханх сумын ЗДТГ-аас Хөвсгөл Эрчим хүч ХХК-д шилжүүлж, сумын айл өрхийг бүрэн тоолууржуулж, 2 ТП -г шинэчилж, 1 ТП-г шинээр угсарч ашиглалтад оруулав. /Б-100%/
20	Эгийн голын 160 у/м төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулж, Идэрийн голын 163,1 у/м төмөр бетон гүүр барьж эхлэн орон нутгийн замын санд 210,0 сая төгрөг хуримтлуулан Мөрөн сумын хатуу хучилттай замыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Түнэл сумын Эгийн голын 160 у/м төмөр бетон гүүрийг ашиглалтанд оруулсан. Жаргалантын Идэрийн голын 163.1 у/м төмөр бетон гүүрийг барьж эхлэн орон нутгийн замын санд оны эхний 11 сард 214.0 сая төгрөг төвлөрүүлээд байна. /Б-100%/
21	Уньт-Тариалангийн хатуу хучилттай зам барьж эхлэн Мөрөн-Хатгалын 98,8 хатуу хучилттай замын ажлыг үргэлжлүүлэн Мөрөн сумын хатуу хучилттай замыг шинэчилнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Уньт-Мөрөнгийн хатуу хучилттай зам барих хөрөнгийг Кувейтын сангийн хөрөнгөөр барихаар, Мөрөн-Хатгалын 98.8 км хатуу хучилттай замын ажлыг үргэлжлүүлэхээр 2010 онд 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн. Мөрөн суманд 1,9 км хатуу хучилттай зам шинээр ашиглалтанд оруулж, 1,9 км замыг засварлаж, нийт 3,8 км хатуу хучилттай зам шинэчилж сайжруулахад 690,0 сая төгрөг зарцуулав. /Б-100%/
22	Хатгал-Ханх чиглэлийн 80 км авто зам барьж эхэлнэ.	Ажлын эхлэлтээр	Хатгал-Ханх чиглэлийн 80 км авто замын ажлыг эхлүүлэхээр ЗТБХБЯ-наас гүйцэтгэгч сонгох тендер зарлагдсан. /Б-100%/
23	Мөрөнгийн Нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвасын шинэчлэлт хийнэ.	Шинэчлэлтийн хэмжээгээр	2010 онд 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдэж, ажлын гүйцэтгэгчээр КТК ХХ компани сонгогдон ажлыг гүйцэтгэж байна. /Б-70%/
24	Аймаг, сумын төвүүдэд ахуйн үйлчилгээний төв байгуулж ажиллуулах ажлыг хувийн хэвшилд тулгуурлан эхлүүлж төрөөс дэмжлэг үзүүлж, олон улсын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрт хамруулна.	Дэмжлэг үзүүлсэн нэгжийн тоогоор	Мөрөн суманд ахуйн үйлчилгээний цогцолбор байгуулах 15,0 сая төгрөгийн төслийг хөнгөлттэй зээлд хамруулж, Байгаль ээж зах дотор ахуй үйлчилгээний цэгийн барилга баригдсан. Сумдын төвүүдэд ахуй үйлчилгээний цэг барьж байгуулах зорилт орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан. /Б-90%/
Зорилт. 9. Мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлж, өрх бүрт хүргэнэ.			
25	Шуудангийн үндсэн сүлжээний мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, нэгдсэн сүлжээ байгуулж, шууданг аймагт долоо хоногт хоёр удаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шуудангийн салбарын хэмжээнд электрон сүлжээ 100 хувь нэвтэрч шууданг бүртгэл хяналтын системээр хянах боломжтой болж, шууданг аймагт зуны улиралд өдөр бүр, өвлийн улиралд 3 удаа хүргэж, Ханх сумаас

	сум багт 7 хоногт нэгээс доошгүй удаа хүргэнэ.		бусад 14 суманд 7 хоногт 1 удаа, 9 суманд 2 удаа хүргэж байна. /Б-90%/
Гурав. Байгаль орчин, бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого:			
1	Ойжуулалт ойн арга хэмжээ, хортон шавьж устгах ажлыг зохион байгуулна.	Амьдралт 70, үхэл 80 хувь байна	Улсын төсвийн хөрөнгөөр 2010 онд 30,8 мянган га талбайд хортон устгах ажлыг Гранд форст компани Рашаант, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Бүрэнтогтох, Жаргалант, Шинэ-Идэр зэрэг 7 сумын нутагт 29130 га талбайг онгоцоор 97 удаагийн нислэгээр 76 цаг 55 минутын авиахимийн нислэг, 3 цаг 12 минутийн маршрутын нислэг нийтдээ 80 цаг 07 минутын нислэг үйлдэж, 1712 га талбайг гараар Зэвсэгт хүчний 186-р ангийн 9 цэрэг ажиллаж, 8 ширхэг утаат багаж ашиглаж, нийт 30842 га талбайд хортон устгалтын ажил тус тус хийсэн. Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлын гэрээг Хөвсгөл Шинэс, МСҮТ, Харгана, Бумбах зэрэг аж ахуй нэгжүүд хийж, сум дундын Дэлгэрмөрөн ойн ангитай байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг /Ойн үрийн модны түр болон байнгын хэсгүүдийг байгуулах/ гэрээгээр гүйцэтгэж, энэ ажлын хүрээнд Тариалан суманд-140 га, Түнэл суманд-60 -га-д тус, тус ойжуулалт, Рашаант суманд 80 га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг хийсэн. Уг ажлыг аймгийн БОАЖГ-ын ойн алба, МХГ-ын байгаль орчны улсын байцаагч, сумдын ЗДТГ-ын ажилтнуудын томилогдсон ажлын хэсэгтэй хамтран явцын шалгалтыг 2010.06.25-27 хооронд хийж, ажлыг бүрэн гүйцэтгэсэн. /Б-100%/
Зорилт 11. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн үндсийг бэхжүүлж, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулна.			
2	Байгаль орчны аймгийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.	Бүх үзүүлэлт орсон байх	Монгол улсын засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолын дагуу аймагт байвал зохих байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд оруулах эх мэдээллийн жагсаалтаар мэдээллийг бүрдүүлж, Хөвсгөл аймгийн байгаль орчны төлөв байдлын 2006-2008 оны тайлан гаргаж, ном болгон албан хэрэгцээнд ашиглаж байна. 2010 онд НҮБ-ын Хамтын эзэмшлийн ойн менежментийн чадавхийг дэмжих төслөөс "Ойн нөхөрлөлийн мэдээллийн сан" бүрдүүлэх программ, Дэлхийн байгаль хамгаалах

			<p>сангийн төлөөлөгчийн газраас ангийн зөрчил, уулын туруутан амьтны мэдээллийн сан бүрдүүлэх программыг УТХГазар, БОАЖГ-т олгов. Алтай-Соёны төслийн нэгжээс Геодези, зурагзүйн газартай хамтран явуулсан газарзүйн мэдээллийн системийн программын анхан шатны 3 өдрийн сургалтанд БОАЖГ-ийн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнийг хамруулав.</p> <p>Ахуйн болон улсын бүртгэлд агнасан ангийн тоо хэмжээг 1960-1990 он, ан агнуурын хууль тогтоомжийн зөрчлийн дэлгэрэнгүй судалгааг 1976-1991, улсын бүртгэлд өгч байсан ангийн мах, арьс зэрэг дагалт судалгааг 1963-1990 он хүртэлх хугацаагаар сум бүрээр, аймагт тархсан нэн ховор, ховор болон “улаан ном”-д орсон, CITES-н хавсралтанд бүртгэгдсэн амьтан, ургамлын тархацын тойм, зүйлийн бүрдлийг гаргасан судалгаа, газрын нэгдмэл сангийн мэдээ, ой, цаг уур, химийн хорт бодисын бүртгэл, ашигт малтмалын лицензийн судалгаа зэргийг оруулаад байна. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, отог, зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлал эрхлэгчдийн судалгааг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэв.</p> <p>/Б-100%/</p>
3	Аймгийн хэмжээний жижиг гол, нуур цөөрөм, уст цэгийн тоо, байршлын судалгааг сум бүрээр гаргаж, мэдээллийн санд хамруулна.	Суурь мэдээлэлтэй болсон байх	<p>Аймгийн хэмжээнд гол, горхи-780, нуур тойром-374, булаг шанд-879, эмчилгээний ач холбогдол бүхий халуун, хүйтэн рашаан -45, мөстөл мөсөн гол-1, цэвэрлэх байгууламж-1, өрөмдмөл худаг-942-т 2007 онд тооллого явуулсан. Дээрх уст цэгүүдийн байршлыг тогтоон мэдээллийн санд төвлөрүүлсэн. 2010 оны усны тоо бүртгэлийг цөлжилттэй холбоотойгоор сүүлийн 30-50 жилд усгүй болж ширгэсэн уст цэгүүдийн судалгаа гаргаж, харьцуулалт хийхэд бэлтгэсэн. 2010 оны 11 сарын 1 нд тооллогын эцсийн дүн гарч Монгол улсын мэдээллийн санд оруулсан.</p> <p>/Б-100%/</p>
Зорилт 12. БАЙГАЛЬ ОРЧИНД ХАЛГҮЙ, ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛНА.			
4	Жуулчны бааз, амралтын газруудын байгаль орчны төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, ерөнхий үнэлгээний шаардлагын	Зөрчлийг бүрэн арилгасан байх	Аймгийн МХГ, БОАЖГ, УЦУОШТ, ГХБХБГ-ын хамтран 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн баталсан удирдамжаар Хөвсгөл нуур орчмын 19 жуулчны бааз, 13 гэр буудал, 10 зочид буудалд хяналт шалгалт хийв. Нийт 50

	хэрэгжилтийг хангуулна.		жуулчны баазын 50 нь байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээнд хамрагдаж байгаль орчны төлөвлөгөө гарган ажиллаж байна. Зөрчилтэй байгууллагуудад МХГ-аас шаардлага хүргүүлж, холбогдох зөрчлийг арилгуулсан байна. /Б-90%/
5	Мөрөн суманд “Аялал жуулчлалын нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулах эхлэлийг тавьж, “Хөвсгөл аймгийн Аялал жуулчлалын нэгдсэн вэб”-ийг интернетэд байрлуулж, аймгийн аялал жуулчлалын газрын зургийг шинээр хэвлүүлэн, Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын лавлах номын эхийг бэлтгэнэ.	Нэг цэгийн үйлчилгээ нээгдсэн байна.	Аймгийн Музей номын сангийн байранд “Хөвсгөл-Аялал мэдээлэл” холбоо ТББ-тай хамтран “Жуулчны мэдээллийн төв” байгуулан байр, ном товхимол, сурталчилгааны материалаар хангаж ажиллаж байна. Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 2010 онд 1000 хувь хэвлүүлэн жуулчдад үйлчилж байна. “Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын вэб” сайтыг ажиллуулж, www.huvsgul.mn вебсайтад аялал жуулчлалын булан нээж, холбогдох мэдээлийг оруулан сурталчилж, Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын лавлах номонд орох материалын судалгаа хийж эхлээд байна. /Б-70%/
Зорилт 3. БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, ОРОН НУТГИЙН ТҮҮХИЙ ЭД , БОЛОМЖ, НӨӨЦӨД ТУЛГУУРЛАСАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИНЭ.			
6	Ханх сум, Хатгал тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хатгал тосгон нуур орчмын ерөнхий төлөвлөгөө хийхээр 2008 онд Проект Х ХХК эхэлсэн боловч, 2009 онд Хөвсгөл нуурын эрэг дээрх жишиг жуулчны баазын зураг боловсруулах аймгийн санал авсан боловч ажлаа дуусаагүй. /Б-30%/
7	Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг баримтлан орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Байгуулах үйлдвэрийн тоо	Монгол улсын Засгийн газрын 2009 оны 178 дугаар тогтоолоор батлагдсан орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн дагуу аймгийн дэд комисс ажиллаж, орон нутгийн төслүүдийг шалгаруулж, ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд 376 аж ахуйн нэгжийн 1,7 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр шийдэгдээд байна. /Б-70%/
8	2010 оныг “Үйлчилгээний соёл, чанарын жил” болгож, аймаг, сумын төвд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллага хүрээлэн байгаа орчноо ногоон байгууламж, гэрэлтүүлэгтэй, цэвэр цэмцгэр болгоно.	үйл ажиллагааны хэрэгжилтээр	2010 оныг “Үйлчилгээний соёл, чанарын жил” болгон зарлаж, аймгийн төвийн байгууллагын орчныг тохижуулах чиглэл өгснөөр аймгийн ЗДТГ, УСНААК, Нисэх буудал, Мөрөн сумын ЗДТГ, ХААН банк, Хадгаламж банк, Дөл буудал, Өгөөж ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллага орчноо тохижуулах ажил зохион байгуулсан байна. /Б-70%/

Зорилт 15. ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ХҮН АМЫН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭДЭД ХҮРГЭХ МЭДЭЭЛЭЛИЙГ ЦАГ АЛДАЛГҮЙ, ТҮРГЭН ШУУРХАЙ ХҮРЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ.

9	Бүх сум, тосгонд Интернет мэдээллийн төв байгуулан хүн амын интернетийн хэрэглээг сайжруулна.	Мэдээллийн төвийн тоо	Сумдад "Интернет мэдээллийн төв" байгуулах 95,0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, дутагдаж буй хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад санал хүргүүлээд байна. Шилэн кабельтай 8 сум, 5 сумын ерөнхий боловсролын сургуулийг интернетэд холбогдсон. /Б-50%/
10	Мөрөн сумын төвд IP/MPLS технологид суурилсан өндөр хурдны түгээх сүлжээг байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хугацаа хойшлогдсон.
11	Бүх сумыг шилэн кабельд холбох замаар үндсэн суурь сүлжээг бүх нийтэд хүртээлтэй болгон, гар утас, интернетийн үйлчилгээг хүргэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	БНХАУ-ын төслийн хөрөнгөөр Хөвсгөл аймгийн бүх сумдыг шилэн кабельд холбохоор судалгааны ажил хийгдэж, ажил 2011 онд хийгдэхээр болсон. Бүх сумдад 1-5 төрлийн үүрэн телефоны үйлчилгээ орсон байна. /Б-70%/

Дөрөв. Ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангах бодлого:

Зорилт 16. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ШИНЭЧЛЭЛ ХИЙЖ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ОНОВЧТОЙ ХҮРГЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.

1	Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуу өрхөд чиглэсэн салбар дундын үйл ажиллагаагаар хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч "Хүнс тэжээл, нийгмийн халамж"-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хүнс тэжээл нийгмийн халамжийн хөтөлбөрт зорилтот 7 бүлгийн 2069 иргэнийг сонгон 2009 оны 11 дүгээр сараас эхлэн хамруулж хамруулж, 2010 оны 08 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 9757 иргэнийг хамруулсны 199 нь тэжээн тэтгэх үр хүүхэд төрөл садангүй ахмад настан, 683 нь байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, 124 нь асран хамгаалах хүнгүй, ганц бие хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан ХБИ, 613 нь байнгын асаргаа шаардлагатай ХБХ иргэд, 219 нь байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхэд, 14 нь бүрэн хараагүй 0-18 насны хүүхэд, 91 нь сэтгэцийн өвчтэй 0-18 насны хүүхдийг хамруулж, 100 аж ахуйн нэгж, иргэдийн хүнсний дэлгүүрүүдтэй хамтран уг төслийг хэрэгжүүлж, 276.5 сая төгрөг зарцуулав. /Б-100%/
2	Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжих зорилгоор "Өрхийн хөгжлийг	Хөтөлбөр батлагдсан байх	Өрхийн хэрэглээ, чадавхи, санаачлагыг дэмжих зорилгоор "Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд

	дэмжих аймгийн дэд хөтөлбөр"-ийг боловсруулж мөрдөнө.		хөтөлбөр" боловсруулж эхлээд байна. /Б -30%/
Зорилт 17. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭН БЭХЖҮҮЛНЭ.			
3	Татвар болон нийгмийн даатгалын шимтгэл хураах нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх асуудлыг судалж, хамтын ажиллагааг сайжруулж, тэтгэврийн сангийн тогтвортой байдлыг хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн нийгмийн даатгалын шинэтгэлийн сангуудын төлөвлөгөө 100,0-110,5 хувиар биелж, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг 113,2 мянган хүнд 11,2 тэрбум төгрөг олгож, аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй 471 байгууллага, аж ахуйн нэгжийг НДШ-д хамруулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 31 байгууллагаар буюу 6.8 хувиар өссөн байна. /Б-100%/
Зорилт 18. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЗАМААР ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ДЭЭШЛҮҮЛЖ, ЯДУУРЛЫН ТҮВШИНГ БУУРУУЛНА:			
4	Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжилттэй ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байран дахь сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хөдөлмөр зарцуулалт ихтэй мэргэжил болон мэргэжлийн ур чадвар шаардахгүй нийтийг хамарсан ажилд 612 иргэнийг хамруулан түр ажлын байраар ханган 71.9 төгрөгийн санхүүжилт олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлд 381 иргэн, 14 аж ахуйн нэгж хамрагдаж, 422.6 сая төгрөгийн бага хүүтэй зээл олгож, 578 байнгын ажлын байр бий болгох төслийг санхүүжүүлэв. Орлогын эх үүсвэртэй болгох зорилгоор хөдөлмөрөө хоршин ажиллаж байгаа хөдөлмөр эрхэлж буй бүлэг иргэдийн ажлын байр бий болгох төслийг сумдын амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрээр 25 бүлгийг 22,5 сая төгрөгийн санхүүжилт олгож, 107 ажлын байр шинээр бий болгов. /Б-100%/
5	Ядуу өрхүүдийн мэдээллийн санг үндэслэн нэн ядуу өрхийн хөдөлмөрийн чадвартай гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авна.	Дэмжлэг авсан хүний тоогоор	ХБХЭЭХолбоо хүүхдийн хөгжил төвийг байгуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдэд мэдээлэл зөвлөгөө өгөх, амьдрах ухааны сургалтыг тогтмол явуулж, өөрсдийн нь хийсэн бүтээгдэхүүний борлуулалтаар орлого олж байна. ХБИ-ийн төсөл сонгон шалгаруулалтанд 59 төслөөс 12 төслийг шалгаруулж, 20,0 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна. /Б-100%/
6	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын	Хамрагдсан хүний тоогоор	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн үзлэгийн дүнд 435 албан бус хөдөлмөр эрхлэгч байгаагийн хувиараа хөдөлмөр эрхлэгч-138, ажил олгогч-15, өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч-36, албан бус үйлдвэрлэлийн

	оролцоотой тэднийг нийгмийн үйлчилгээнд хамруулна.		хоршооны гишүүн-12, албан ба албан бус хэвшлийн аж ахуйн нэгжид ажиллаж буй хөлсний ажилчин -211, өрхийн бизнест цалин хөлстэй оролцогч-23 нийгмийн даатгалын багц хууль, хөдөлмөр эрхлэлтийн хууль тогтоомжоор сурталчилгаанд хамрагдав. /Б-30%/
Зорилт 19. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН АМД ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ ҮЗҮҮЛЖ, ЕРДИЙН БОЛОН ХАЛДВАРТ ӨВЧНИЙГ БУУРУУЛЖ, ДУНДАЖ НАСЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХЭД ЧИГЛҮҮЛНЭ.			
7	Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн Засаг даргын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 235 дугаар захирамжаар ХХЭМБ-дад сонгон шалгаруулах комиссыг 8 хүний бүрэлдэхүүнтэй томилж хэвтэн эмчлүүлэх ор бүхий 7 хувийн эмнэлэг, рашаан сувилалын 1 байгууллагыг сонгон шалгаруулалтанд оруулж, үнэлгээ хийж дүнг Монгол улсын Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, 2010 оны эхний 5 сарын байдлаар 7 ортой эмнэлэг болон 1 рашаан сувилалын газарт нийтдээ 151,7 сая төгрөгийн эрүүл мэндийн даатгалын санхүүжилт хийсэн байна. /Б-100%/
8	Сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон орон нутагт ажиллах эмч нарын дэмжлэгийг бий болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулна.	Эмчийн тоогоор	Аймгийн ИТХ-ын 42 дугаар тогтоолын дагуу 2010 онд 29 их эмчийг гэрээгээр ажиллуулж, сар бүр 100,0 мянган төгрөгийн урамшуулал олгож байна. 2010 оны эхнээс Хатгал, Тосонцэнгэл, Бүрэнтогтох, Чандмань-Өндөр, Галт, Цэцэрлэг сумдыг шинээр их эмчээр хангаж, 3 их эмчийг резидентийн сургалтанд 12 сувилагч, бага эмчийг мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамруулж, Эрүүл мэндийн яам болон бусад аймаг хотод урт, богино хугацааны сургалтанд 65 их эмч, мэргэжилтнийг хамруулав. /Б-100%/
9	Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм хэрэгслэлээр тогтмол хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сум, өрхийн эмнэлгийн төрөх насны эмэгтэйчүүдээс судалгаа авч ЖХЭХ-ийн хэрэглээнд хяналт тавьж, ЖХЭХ-ээр хангаж, жирэмсэн эмзэг бүлгийн 23 иргэнийг 1 өдрийн "НҮЭМ-ийн мэдлэг хайх" сургалтанд хамруулж, гарын авлаг материалаар хангасан. /Б-70%/
10	Эрүүл мэндийн үйлчилгээнд "Урьдчилан сэргийлэх нь эмчлэхээс хялбар" зарчмыг баримталсан шинэ аргачлал нэвтрүүлж, иргэдийг эрүүлжүүлэх арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зан үйлийг төлөвшүүлэх тусгай арга хэмжээ зохион байгуулах удирдамж гарган тодорхой зорилтот бүлгүүдийг сонгон урт хугацааны үн дүнг тооцох аргачлалыг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. /Б-90%/
11	Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн ЭМГ, ДЗОУБ-ын ОНХХэлтэстэй хамтран Их-Уул, Мөрөн сумын Ирээдүй, Гурван-Эрдэнэ, Эрдмийн далай

	аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж хэрэгжүүлэх		зэрэг сургуулиудад хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор шүдний эм хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангаж, 5,7 мянган хүүхдийг хамруулж, 3,1 мянган хүүхдийг эмчлэн эрүүлжүүлж, холбогдох эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах, шүдний кабинетуудын багаж тоног төхөөрөмжинд үнэлгээ хийхээр төлөвлөж байна. /Б-50%/
Зорилт 20. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ГҮНЗГИЙРҮҮЛЖ, БҮХ ШАТНЫ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХҮРТЭЭМЖ, ЧАНАР, ТЭГШ БАЙДАЛД БОДИТОЙ АХИЦ ГАРГАНА:			
12	Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, баг бүрийг гэр цэцэрлэгээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.	Хамрагдалтын хувь, гэр цэцэрлэгтэй болох багийн тоо	Аймгийн хэмжээгээр хөдөөгийн 109 багт гэр цэцэрлэг, Мөрөн сумын 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр цэцэрлэгт зуны 2 бүлэг ажиллав. /Б-90%/
13	Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хэрэгжүүлж эхэлнэ.	Стандарт хангалтын хувь	Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт БСШУЯ-наас батлагдаагүй ба стандартын төслийг танилцуулж, сургалтанд хэрэглэх боломжийг судалж байна. /Б-30%/
14	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэн сургуульд суурилсан мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Үйлийн явцад суралцахуй сургалтыг 3 үе шаттай зохион байгуулж 1 дүгээр үе шатанд ЗАН ахлагч-78, 2 дугаар үе шат-бүсэд багш, удирдах ажилтан-450, 3 дугаар үе шат-сургуулийн түвшинд багш нар-1200 хү тус тус хамрагдав. /Б-90%/
15	Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн тоог нэмэгдүүлж, багш нарыг зөөврийн компьютерээр хангах арга хэмжээг үргэлжлүүлнэ.	Компьютерийн тоогоор	ЕБС-ийн компьютерийн тоог нэмэгдүүлэх талаар БСШУЯ-нд хүсэлтээ тавьж, 2010 онд шинээр 45 компьютерийг сургалтанд зориулан хэрэглэж байна. /Б-30%/
16	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Үдийн хоол хөтөлбөр”-т хамруулах ажлыг эхлүүлэх.	Хамрагдсан хүүхдийн тоогоор	2009-2010 оны хичээлийн жилд аймгийн 33 сургуулийн 1-5-р ангийн 13738 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдсан. Орон нутагтаа хүнсний чиглэлээр үйлчилгээ эрхэлдэг 6-8 аж ахуйн нэгж бүтээгдэхүүнээ нийлүүлж байна. /Б-90%/
17	Сургууль завсардалтыг бууруулж, бүх хүүхдэд бага боловсрол олгоно.	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин /хувиар/	2010 оны хичээлийн жилийн байдлаар сургууль завсардалтын хувийн жин-1,7 хувиар буурч, бага боловсролын хамран сургалтын цэвэр жин өнгөрсөн оны мөн үеийнхээс 2,7 хувиар нэмэгдсэн байна. /Б-70%/
18	Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, стандартыг зах зээлийн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Мэргэжлийн боловсролын сургалтын арга зүйг шинэчлэн, багшлах боловсон хүчнийг чадваржуулан сургуулийн

	эрэлтэд нийцүүлэн шинэчилж, МСҮТ-ийг аттестатчилна.		удирдлагыг сонгон шалгаруулалтанд оруулан сонгож, зах зээлийн эрэлтэд нийцсэн 9 мэргэжлээр 12 бүлэгт элсэлт аван элсэгчдийн тоог 20 хувиар нэмэгдүүлэв. /Б-50%/
Зорилт 22. Соёл, урлагийг хөгжүүлэх, эрх зүйн боловсронгуй болгож, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг ахиулж, хүний хөгжлийн хэрэгцээнд чиглүүлнэ:			
19	“Монгол Улсын соёл, урлагийг 2010-2016 онд хөгжүүлэх, мастер төлөвлөгөө”-г боловсруулж батлах:	Хөтөлбөр батлагдсан байх	Монгол улсын соёлын хэтийн чиглэл, Соёл урлагийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө шинэчлэгдэж байгаатай холбогдон хөтөлбөрийн төсөл боловсруулж эхлээд байна. /Б-30%/
20	Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг, ном товхимолын хангалтыг нэмэгдүүлэн, алслагдсан нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх соёлын явуулын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх арга хэмжээ авах.	Багийн тоо, хамрагдсан хүний тоо	ХДТ-д хөгжим техник хэрэгсэл, гэрэл чимэглэлийг сайжруулахад 21.0 сая, 20 сая төгрөгөөр фурган машин, 5 ардын хөгжим олгосон. Аймгийн Музейн үзмэр, үзүүллэгийг дэглэж, “Экологийн танхим”, “Эргэншлийн танхим”, “Түүх угсаатны зүйн танхим”-ийг дохижуулахад-25,0 сая төгрөг зарцуулж, Баг-88 арга хэмжээг зохион байгуулж, 9 сумын 47 багийн 5000 гаруй иргэдэд цаг үеийн мэдээлэл, соёл, урлаг, эрүүл мэнд, ахуйн үйлчилгээгээр үйлчлэв. /Б-50%/
Тав. Гадаад бодлого, батлан хамгаалах			
1	ОХУ, БНХАУ, Герман, Солонгос, Тайвань улсуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ.	Харилцаа тогтоосон улсын тоогоор	ОХУ-тай уламжлалт хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, 2010 онд ОХУ-ын Тува улс, Буриад улсын улсын Түхэн, ахын аймгийн удирдлагууд Хөвсгөл аймагт, тус аймгийн төлөөлөгчид дээрх улс, районуудад харилцан айлчлав. 2010 оны 6 дугаар сарын 25-27-нд ОХУ-ын Буриад улсын Түнхэн аймагт зохион байгуулж, уг наадамд аймгийн ИТХ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын дарга Ханх, Чандмань-өндөр сумдын удирдлага, урлаг соёлын ажилтнууд нийт 27 хүн оролцов. 2010 оны 7 дугаар сард зохион байгуулсан “Хотгойд хурд-2” наадамд ОХУ-ын Тува улсын ХХААҮЯ-ны сайд тэргүүтэй төлөөлөгчид, ОХУ-ын Буриадын Түнхэн, Ахын аймгийн удирдлага, төлөөлөгчид оролцов. 11 дүгээр сард Буриадын төлөөлөгчид Хөвсгөл аймагт айлчилж, Мөрөн сум, Алаг-Эрдэнэ, Цагаан-уул, Тосонцэнгэл зэрэг 4 сум Буриадын Түнхэн аймгийн 5 сууринтай шууд хамтын ажиллагаа тогтоож, баталгаажуулан протокол бичиг үйлдэв. Аймгийн гадаад харилцааг өргөжүүлж, өндөр хөгжилтэй орны муж

			<p>хотуудтай шууд хамтын ажиллагаа тогтоох зорилгоор 2010 онд Солонгос, Хятад, Франц дахь Монгол улсын ЭСЯ, МУ-д суугаа Франц, Энэтхэгийн ЭСЯ, Тайванийн төлөөлөгчийн газруудад албан захидал, тодорхой санал, хүсэлтийг Хөвсгөл аймгийн болон холбогдох сумдын танилцуулга, бусад мэдээллийн хамт англиар орчуулан бэлтгэж хүргүүлэв. Одоогоор БНСУ-ын "Гангнын" хоттой нийгэм соёл, эрүүл мэндийн салбарт, Францын "Дээд савуа" мужийн Тонон хоттой нуур ус судлал, байгаль, байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах боломжтой тухай хариу ирсэн. Монгол улсаас Шведийн Вант улсад суугаа ЭСЯ-ны саналын дагуу хамтран тус улсын улсын Нордботтен мужтай шууд хамтын ажиллагаа тогтоох тухай санал, холбогдох мэдээллийг бэлтгэн явуулсан ба Хөвсгөл аймгийн цаатан иргэдийн төлөөлөгчдийг тус мужид айлчлуулж, туршлага судлуулах талаар ярилцаж байна. Аймгийн удирдлага болон төрийн байгууллагын төлөөлөл дээд байгууллагуудын шугамаар Герман, Вьетнам зэрэг оронд туршлага судлав. Зүүн хойд Азийн засаг захиргааны нийгэмлэгийн шугамаар БНХАУ, БНСУ-д зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд аймгийн төрийн байгууллагын төлөөлөл 2010 онд 2 удаа оролцов. /Б-10%/</p>
2	Эх орныхоо түүх, соёл, хөгжлийг гадаадад сурталчлах таниулах, эерэг ойлголтыг бэхжүүлэх чиглэлээр идэвхитэй ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	<p>Аймгийн онцлог, түүх соёлыг сурталчлах зорилгоор "Чингүнжавын 300 жилийн ой"-г тэмдэг ажлын хүрээнд англи, орос, монгол тайлбар бүхий Хөвсгөл аймгийн зурагт танилцуулга-товхимолыг 1000 ш-ийг 2.8 сая төгрөгөөр хэвлүүлэн ойн арга хэмжээнд оролцогчдоод өгөв. АНУ-ын Монтана мужийн -Эгч дүү орнууд" төслийн санаачлага, дэмжлэгээр аймгийн олон ястны өвөрмөц соёлыг хамгаалах, сурталчлах зорилго бүхий "Дархад ардын урлаг, соёлын наадам", "олон ястны урлагийн наадам"-ыг 2010 оны 6 дугаар сарын 19-21-ны өдрүүдэд Мөрөн суманд зохион байгуулав. 2010 онд БНСУ, БНХАУ, БНФУ дахь Монгол улсын ЭСЯ болон Монгол улс дахь Францын элчин сайдын яам, Тайваны төлөөлөгчийн газарт Мөрөн сум, Хөвсгөл аймгийн тухай танилцуулга-мэдээллийг англи, монгол хэлээр бэлтгэж, файл хэлбэрээр хүргүүлэв. Аймгийн засаг даргын гадаад бодлогын зөвлөхтэй хамтран Цагаан-үүр сумын танилцуулгы франц хэлээр бэлтгэж тус улсын</p>

			ЭСЯ-д хүргүүлэв. Монгол улсаас Шведийн Вант улсад суугаа ЭСЯ-д Цагааннуур сумын тухай мэдээллийг бэлтгэж 2010 оны 4 дүгээр сард хүргүүлж, аймгийн huvsgul.mn веб сайтын загвар дизайныг шинэчлэн тогтмол ажиллуулж, аймгийн ЗДТГ-ын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан цаг үеийн мэдээллээр тогтмол хангаж, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын тухай мэдээллийг оруулах, шинэ үйлчилгээ суулгах бэлтгэл хийж байна. /Б-90%/
Зорилт 25. БАТЛАН ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БАТЛАН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛНЭ.			
3	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан мөрдөж, дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалт зохион байгуулна.	Төлөвлөгөө, сургалтын тоогоор	Аймгийн дайчилгааны төлөвлөгөөг шинэчилэн боловсруулж, тодотгол хийж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний I зэргийн үүрэгтний сургалтыг 2010 оны 9 дүгээр сарын 20-ноос эхлэхээр бэлтгэл хангасан. /Б-50%/
Зорилт 28. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЭЧЛЭЖ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭЛБЭРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МАТЕРИАЛЛАГ БААЗЫГ САЙЖРУУЛЖ, БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛНЭ:			
4	Хууль тогтоомж зөрчих явдлыг хязгаарлаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын үр нөлөөг сайжруулна.	үйл ажиллагаагаар	2010 оны эхний 11 сарын байдлаар хууль тогтоомжийн сурталчилгааг, хууль хяналтын байгууллагууд 71 удаа зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлснээс гарсан гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 1,2 хувиар буурсан. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг-0,6, авто аваарын гэмт хэрэг-12,5, малын хулгайн гэмт хэрэг-69,5, насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэг-5,2 хувиар, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэгт холбогдогчийн тоо -22,5 хувиар тус тус буурсан байна. /Б- 100%/
Зорилт 29. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОЖ, ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРГЭХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АВРАХ, ГАМШГИЙН АЮУЛЫГ БУУРУУЛАХ, ХОР УРШГИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ АВНА:			
5	Бүх шатны байгууллагуудын гамшгаас хамгаалах арга хэмжээг боловсронгуй болгож, гамшгийн эрсдлийн санг байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн Засаг даргын шийдвэрээр гамшгаас хамгаалах сан байгуулж, санг бүрдүүлэх зарцуулах журам гарган иргэд аж ахуйн нэгж байгууллага, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр сангийн хөрөнгийг бүрдүүлж одоогын байдлаар тус сангийн хөрөнгө зуу гаруй сая төгрөгийн

			үлдэгдэлтэй байгаа ба өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зарцуулах шийдвэр гарган ажиллаж байна. /Б-100/
Зорилт 32. УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН НӨӨЦИЙ БҮРДҮҮЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛНА.			
6	Аймаг, сумдын хэмжээнд орон нутгийн гамшгийн нөөцтэй байх чиглэлээр өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээ авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол улсын Засгийн газрын 166 дугаар тогтоолын дагуу аймгийн нөөцийг бэлтгэж байна. 2010 оны эхний 11 сарын байдлаар сумын фондод зориулж-138 тн, багийн фондод зориулж-67 тн, Хот тохижилт үйлчилгээний компани-20 тн, Улаанзагалмай хүмүүнлэгийн байгууллага-60 тн өвс бэлтгээд байна. /Б-90%/
Зургаа.Засаглал, эрх зүйн шинэчлэл:			
Зорилт 33. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮНГ САЙЖРУУЛНА.			
1	Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хянах цахим, нээлттэй системийг бий болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Бүх сум, тосгоны Засаг даргын тамгын газрын архив албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудад 2010 оны 12 дугаар сараас шинээр компьютер авч өгч, архивын программ суулгаж, сургалтанд хамруулах бэлтгэлийг хангаснаар аймаг, сумдын ЗДТГ-т ирсэн өргөдөл гомдлын мэдээллийг цахим сүлжээгээр солилцох боломж бүрдэв. /Б-90%/
2	Төр, иргэний нийгмийн харилцан түншлэлийг бэхжүүлж хөгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2009 оноос аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж эхэлсэн "Тогтмол" ажлуудын жагсаалтыг шинэчлэн гаргаж, аймгийн ЗДТГ-ын даргын 2010 оны А-10 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Төр ба хамтын зүтгэл нээлттэй өдөрлөгийг 2010 оны эхний 8 сард 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 3,0 мянга гаруй иргэдэд мэдээлэл өгч, аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Боловсролын байгууллагууд иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа, санал асуулга авч дүгнэлт хийв. /Б-70%/
3	Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, төрийн бодлого, үйл ажиллагааны хяналт-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2010 оны Төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, иргэдтэй ажиллах жил" болгон зарлаж, жилийн ажлыг зохион байгуулах аймгийн хороог аймгийн Засаг даргын 2010 оны А-02 захирамжаар байгуулж,

	шинжилгээ, үнэлгээний чанар үр өгөөжийг сайжруулна.		2010 оны 05 дугаар сарын 5 нд аймгийн “Төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөн” зохион байгуулж, уг зөвлөгөөэнд 300 төлөөлөгч оролцуулж, аймгийн нийт төрийн байгууллага, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх талаар “Уриалга” гарган, 1 өдрийн сургалт% семинар зохион байгуулав. Монгол улсын Засгийн газрын 2006 оны 160, 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Монгол улсын Засгийн газрын шийдвэр, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр холбогдох хэлтэс, байгууллагаас гаргуулан авч хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, ЗГ-ын хэрэг эрхлэх газарт тайланг хүргүүлж байна. 2010 оны эхний хагас жилийн байдлаар нийт 74 үндэсний хөтөлбөрийн 1466 заалтын хэрэгжилт 36,6, Засгийн газрын 142 шийдвэрийн 220 заалтын хэрэгжилт-69.3 хувьтай байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 агентлаг, 23 сум, 1 тосгоны 2009 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын 2010 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А-117 дугаар захирамжаар үр дүнгийн үнэлгээний үр дүнд 3,0 сая төгрөгийн урамшуулал олгов. /Б-70%/
4	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймаг, сумдын сан байгуулан мал хамгаалах малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн сан байгуулах аймгийн ИТХ-ын шийдвэр гарсан. Цэцэрлэг, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Тариалан, Бүрэнтогтох зэрэг сумдад мал хамгаалах сан байгуулж, 0,3-1,0 сая төгрөгийн хөрөнгө хуримтлуулан сангийн журмын дагуу зарцуулж байна. Тариалан, Хатгал, Түнэл, Арбулаг, Ренчинлхүмбэ, Цагаан-Уул, Төмөрбулаг сумдад малчны мал хамгаалах бүлэг байгуулан ажиллаж байна. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан байгуулаагүй сумдыг сан байгуулах, сангийн хөрөнгийн хэмжээг 300,0 мянган төгрөгөөс доошгүй байлгах зөвлөмж гарган хүргшүүлээд байна. /Б-70%/
5	Төр-иргэний итгэлийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, ил тод, шударга, хүнд сурталгүй болгож, бүх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2010 онд аймгийн ЗДТГ-аас 10 төрлийн тогтмол ажлуудыг ТЗҮХ зохион байгуулж, хэвшүүлээд байна. Тухайлбал: ЗДТГ-ын ажилтнуудыг чадваржуулах, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Мэдээллийн цаг”, “Хуулийн цаг”, агентлаг, байгууллага, аж ахуйн

	<p>шатны төрийн албан хаагчийн ажил үүргийн биелэлтийг дүгнэж, ажлын гүйцэтгэлд мониторинг хийж, цалин урамшуулалтай нь холбож, хариуцлагыг дээшлүүлнэ.</p>		<p>нэгжүүдийн удирдлагын ажил хэргийн уулзалт, цугларалт, “Төр ба иргэн- хамтын зүтгэл” нээлттэй өдөрлөгө зэргийг тодорхой удирдамжийн дагуу зохион байгуулж байна. Аймгийн хэмжээнд 2010 оны эхний хагас жилд нийт төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэлийг хянаж, ажлын хариуцлага, үр дүнгээр нт цалинжуулахаар аймгийн ЗДТГ-ын 2010 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б-14 дүгээр тушаалаар дахин шинэчлэн тогтоож, мөрдөн ажиллаа. Төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, иргэдтэй ажиллах жилийн хүрээнд хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандаж, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн 2 төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлж, 1 төрийн албан хаагчийн албан тушаалыг бууруулж, 2 төрийн албан хаагчийн цалинг 20 хувиар бууруулах арга хэмжээ авав. Салбар зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ-ын даргын сонсголыг хэлэлцэж, аймгийн ТАСЗ-ийн 2010 оны 12 дугаар тогтоолоор сум болон эрхлэх хүрээний газар, хэлтэс, албадын дарга нарт төрийн байгууллагуудын зорилт, төрийн албаны стандартыг хангаж ажиллах талаар тодорхой чиглэл өгсөн.</p> <p style="text-align: right;">/Б-90%/</p>
<p>Зорилт 35. ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЖ, ШААРДЛАГАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛЭЭР ХАНГАНА.</p>			
6	<p>Төрийн архивын хадгалалтын найдвартай нөхцлийг бүрдүүлж, мэдээлэл, эрэлт хайлтын автоматжуулсан нэгдсэн сан байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд цахим бичиг хэргийн тогтолцоог нэвтрүүлэх.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>Аймгийн Архивын барилга бариулах, ERMS программыг суурилуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж, аймаг, сумдын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтнуудад 27 ш компьютер, төрийн архивт канон, принтер, 1 сервер авахад-31.2, ERMS программ авахад 5,0 сая нийт -36,2 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, төрийн архив, сумдын ЗДТГ-ын архивыг сүлжээгээр холбоход бэлэн болсон.</p> <p style="text-align: right;">/Б-70%/</p>
7	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийн</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр 15 суманд 20 олон нийтийн байцаагч ажиллуулж, харилцан адилгүй урамшуулал олгож, нийтийн эргүүлд давхардсан тоогоор 103 байгууллагын 368 иргэд, байгууллагын ажилчид, цагдаагийн албан хаагчидтай хамтран ажиллав. 2010 оны эхний 11 сард олон нийтийн</p>

	хамтын ажиллагааг өргөжүүлнэ.		байцаагчид 237 зөрчил илрүүлэн шийдвэрлэж, зарим зөрчлийг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлсэн. /Б-90%/
8	Цагдаагийн кабон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, аймгийн Цагдаагийн хэлтсийг техник хэрэгслэлээр хангана.	Объектын тоо	Аймгийн Цагдаагийн хэлтэст 20.0 сая төгрөгөөр автомашины граш барьж, 10,0 сая төгрөгөөр радио холбооны станцыг хөдөлгөөнт эргүүлийн 5 машинд суурилуулан ашиглалтанд оруулж, Цагааннуур суманд Цагдаагийн кабон барьж, 2011 оны хөрөнгө оруулалтаар сумдад цагдаагийн кабон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлэв. /Б-100%/

НЭГТГЭСЭН:

АЙМГИЙН ХБХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДАМДИНДОРЖ

ХЯНАСАН:

АЙМГИЙН ХБХ-ИЙН ДАРГА

Х. ГАН-ОЧИР

2011 оны 03 дугаар сарын 25 ний өдөр